

Баянгол Зочид Буудал ХК



**2019 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан**

Агуулга

1. Компаний тухай товчхон
2. Онцлох үйл явдлын хураангуй
3. Санхүүгийн тайлан түүний шинжилгээ
4. Хувьцааны зах зээл
5. Удирдлага

I. КОМПАНИЙ ТУХАЙ ТОВЧХОН

Баянгол Зочид Буудал ХК-нь 1964 онд анх байгуулагдсан бөгөөд 1991 онд хувьцаат компани болж хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болон өөрчлөгдсөн.

2003 оны 6 дугаар сард явагдсан Улсын мэргэжлийн хяналтын алба, Дэд бүтцийн яам, Аялал жуулчлалын газраас буудлуудын зэрэглэл тогтоох үзлэгээр 4 одтой зочид буудал болсон байна.

Одоогийн байдлаар 360 орчим зочин хүлээн авах, таван ангилалын 205 өрөөтэй. Рестораны хувьд 300-450 хүн зэрэг хүлээн авах “Баянгол ресторан”, үндэсний хоолоор үйлчлэх “Монголын нэг өдөр ресторан”, дээд зэрэглэлийн виноны “Wine House” кафе-баараар үйлчлэхээс гадна зочны угаалга, өрөөний үйлчилгээ, үсчин гоо сайхан, интернет зэрэг 20 гаруй төрлийн дагалдах үйлчилгээг зочдод үзүүлж байна.

Эрхэм зорилго

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-нь ЗОЧДОО ДЭЭДЭЛСЭН, ЗОЧИН БҮРТЭЭ ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ ҮЙЛЧИЛДЭГ БАЙГУУЛЛАГА БАЙНА.

Алсын хараа

“Баянгол Зочид Буудал” ХК-нь зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж, олон улсын үйлчилгээний стандарт, дэвшилтэт шинэ үйлчилгээ, техник төхөөрөмж ашиглан, чадварлаг баг, ажилтантайгаар “Баянгол бренд”-ийн үйлчилгээг бий болгоно.

Зорилт

Зочид гийчдийн ая тухтай орчныг бүрдүүлэх хөрөнгө оруулалт хийж, мэргэжлийн туршлагатай МЭРГЭШСЭН баг-хамт олон үйлчлүүлэгч бүрийн сэтгэлд нийцсэн шинэлэг үйлчилгээгээрээ буудлын ор ашиглалтыг бууруулахгүйгээр, борлуулалтын нийт орлогыг 8,5 тэрбум төгрөг болгож, татварын өмнөх ашгийг өнгөрсөн оны хэмжээнд байлгахаар зорьж байна. 2018 оны 2 дугаар сараас эхэлсэн “ISO 9001:2015 чанарын стандарт”-ыг нэвтрүүлэх ажил сургалт болон аудитын үе

шатыг амжилттай дуусгаад 2019 оны 4 дүгээр улиралд багтаан батламжаа авахаар бэлтгэж байна.

“ISO 9001:2015 чанарын стандарт” нэвтрүүлэлттэй холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- Зочдын санал хүсэлтийг хүлээн авч боловсруулан цаашид хэрэглэгч үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэх үйлчилгээг бий болгохоор ажиллаж байна.
- Компаний хэмжээнд дотоод аудит хийн эрсдэл болон үл тохиролыг тодорхойлж түүнийг арилгах засаж сайжруулах төлөвлөгөөт ажил болгосноор үйлчилгээний чанар нэмэгдэж байна
- Сар бүр нийт ажилчидаа “Ажлын үнэлгээний дүгнэх хуудас”-аар дүгнэн орлого ашгийг өсгөх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч байна.

II. ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ


- 2019 оны 5 дугаар сарын 1-7-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Холливуд Монголд” Олон Улсын Кино Уран Бүтээлчдийн анхдугаар наадамд манай компани ивээн тэтгэгч байгууллагаар хамтран ажиллалаа.



- 2019 оны 04 дүгээр сарын 25нд “Баянгол Зочид Буудал ХК”-ийн ээлжит Хувьцаа эзэшигчидийн хурал зохион байгуулагдаж нийт хувьцаа эзэмшигчид 2018 оны ажлын гүйцэтгэлтэй танилцаж, ТУЗ-ийн 2019 оны төсвийг баталлаа. ХЭХурлаар 2018 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 355 төгрөгийн ашиг хуваарилахаар тогтоож 2019 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн компани дээрээ олгохоор шийдвэрлэлээ.



- Сар шинийн баярыг угтан “Баянгол Зочид Буудал ХК”-нь уламжлал ёсоор олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлж хүлээн авлаа.



- 1 дүгээр сард “Mongol Fighting Championship 2019”-Холимог тулааны олон улсын тэмцээний зочид болон 3 дугаар сард “Хөлбөмбөгийн азийн аварга шалгаруулах тэмцээн”-ий тамирчид Баянгол зочид буудалд тухлан саатлаа.



- “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр” болон “Эр цэргийн баярын өдөр”-г тохиолдуулан нийт үйлчлүүлэгчиддээ зориулан ази, европ болон монгол хоолны тусгай сэт меню гарган үйлчилсэн нь үйлчлүүлэгчидийн талархалыг ихэд хүлээн, үнэлэлт дүгнэлт өндөр байлаа. Мөн
3 дугаар сарын 5нд – “Эмэгтэй Автозамчидын Холбоо”-ны баярын арга хэмжээ, 3 дугаар сарын 6нд – “Ардчилсан Холбоо”-ны эмэгтэйчүүдийн баярын арга хэмжээ,
3 дугаар сарын 7нд – “Авто Тээврийн Үндэсний Төв”-ийн эмэгтэйчүүдийн баярын арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Онц сурлагатан” хүүхдүүдээ хүлээн авч үндэсний үйлдвэрээ дэмжин гарын бэлэг гардуулан өглөө.




- 2019 оны компаний төлөвлөгөө, ТУЗ-ийн хурлаар баталсан төсвийн дагуу зочид гийчдийн тав тухтай байдлыг хангах зорилгоор А буудлын стандарт өрөө, люкс өрөө, коридорын засвар, тавилга шинэчлэх, зочны хангамжын зардал зэрэгт эхний хагас жилийн байдлаар 1.83 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг гүйцэтгэсэн байна. Хөрөнгө оруулалт, их засварын ажлыг тендер сонгон шалгаруулан 4-5 компанийг сонгон 2019 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл амжилттай дуусгасан.
- Үүнээс буудлын их засварын зардалд 54%, саун фитнесийн их засварт 14%, фитнесийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд 1,7%, буудлын тавилга шинэчилэлд 19%, хөшиг гэрэл солиход 1,9%, ТВ сувгийн шинэчлэлд 1,9%, өрөөнд эйр кондишн сольж суурилуулахад 1%, гал тогоонд тоног төхөөрөмж шинэчлэлд 0,8%, зочны хэрэгцээнд хангамжийн материалд 6% тус тус зарцуулсан.
- А буудлын 3 дугаар давхарыг бүхэлд нь фитнес, үсчин, маникюр, педикюр, гоо сайхны салон гэх мэт үйлчлүүлэгчид болон зочид гийчдийн тав тухтай байдал, нэг дороос олон үйлчилгээг зэрэг авах боломжоор ханган тохижуулж засварлалаа. Сауныг засч тохижуулан уурын саун, хуурай саун, жакузи, шүршүүр гэх мэт иж бүрэн сауныг ашиглалтанд орууллаа.



- Мөн фитнес төвд мэргэжлийн багш сонгон ажиллуулж, үсчинд монголдоо тэргүүлэх зэргийн “Матрикс” үсчиний салонтой гэрээлэн ажиллаж эхэлсэн.




Standard single room



Standard twin room




Deluxe single room



Deluxe twin room

- Зочдын тав тухтай байдлыг хангахаар А буудлын 10 давхарын нийт өрөөг гэр бүлийн өрөө болгон тохижуулсан.



- Буудлын их засвар шинэчлэлийн ажилтай холбогдуулан хуучин ашигладаг байсан Supervision кабелийн системийг өөрчилж Skymedia компанитай гэрээ байгуулан ТВ сувгийн шинэчлэл хийсэн. Ингэснээр зочдын хүссэн телевизийн сувгууд гарахаас гадна төлбөр тооцооны хувьд сар бүр тогтмол төлбөр төлдөг байсан төлбөрийг улирлын чанартай буюу жуулчдын сезонтой уялдуулан кабелийн төхөөрөмжүүдийг хэсэгчилэн хаах, нээх зэргээр зөвхөн хэрэглээгээрээ төлбөрөө төлөх боломжтой болж байгаа юм.

III. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн байдлын тайлан

/Мян.төг/

Үзүүлэлт	2018.06.30	2019.06.30
Эргэлтийн хөрөнгө	29,674,249	30,904,795
Эргэлтийн бус хөрөнгө	6,606,683	7,453,293
Нийт хөрөнгийн дүн	36,280,932	38,358,088
Өр төлбөр	6,946,297	6,182,439
Эзний өмч	29,334,635	32,175,649
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	36,280,932	38,358,088

- Ажлын цэвэр капитал

$АЦК_{2018} = 29,674,249 - 6,302,633 = 23,371,616$

$АЦК_{2019} = 30,904,795 - 6,182,439 = 24,722,356$

Ажлын цэвэр капитал гэдэг нь эргэлтийн бүх хөрөнгөөс гадны эх үүсвэрийн санхүүжилт буюу өр төлбөрийг барагдуулаад цаана нь өөрийн хэдий хэмжээний эргэлтийн хөрөнгө буюу өөрийн ажлын капитал байгааг харуулдаг. Дээрх үзүүлэлт нь **2018** онд **23,37** тэрбум төгрөг байсан бол **2019** онд **24,72** тэрбум төгрөг болж **5,7%**-р өссөн байна. Энэхүү үзүүлэлт нь хэдий чинээ өндөр байна тэр хэмжээгээр гадны эх үүсвэрээс хараат бус байна.

- Эргэлтийн харьцаа

$ЭХ_{2019} = 30,904,795 / 6,182,439 = 4.99$

Зах зээл хөгжсөн орнуудад эргэлтийн харьцаа нь 2/1 буюу өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөөрөө 2 дахин түүнээс дээш барагдуулах чадвартай бол зохистой гэж үздэг манай байгууллагын хувьд эргэлтийн харьцаа нь **2018** онд **4.21** байсан бол **2019** онд **4.99** болж өссөн нь эргэлтийн хөрөнгө нэмэгдэж өр төлбөрийн хэмжээ буурсантай холбоотой.

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

$$\text{ТТГЧХ}_{2019} = (30,904,795 - 1,114,489) / 6,182,439 = 4.81$$

Уг харьцаа нь 2018 онд 4.1 байсан бол 2019 онд 4,81 болж өссөн сайн үзүүлэлттэй байна

- Дансны авлагын эргэц

Авлагын эргэлтийн харьцаа нь тайлант үед авлага нь хэдэн удаа эргэж мөнгө болсныг харуулна. **2018** онд авлагын харьцаа **3,45** байсан бол **2019** онд **2,85** байна.

- Бараа материалын эргэлт

$$\text{БМЭ}_{2019} = 1,738,007 / 1,114,489 = 1.56$$

Бараа материалын эргэц нь барааг хэр хурдан борлуулж байгааг харуулдаг үзүүлдэг юм. Манай байгууллагын хувьд дундаж бараа материал **2018** онд **1.46** удаа борлуулагдаж байсан бол **2019** онд **1,56** болж **6,8%** хурдан борлуулж байгаа үзүүлэлттэй байна.

- Эргэлтийн хөрөнгийн эргэц

$$\text{ЭХЭ}_{2019} = 2,141,207 / 30,904,795 = 0.07$$

Дээрх харьцаа нь эргэлтийн хөрөнгөө хэр зэрэг ашиглаж байгааг харуулдаг харьцаа юм. Нэг төгрөгний борлуулалт хийхдээ **2014** онд 0,08 мөнгийг зарцуулж байсан бол **2019** онд **0,07** мөнгөний эргэлтийн хөрөнгө зарцуулж буурсан нь борлуулалтын орлогын бууралттай холбоотой.

- Бие даах чадварын коэффициент

$$\text{БДЧК}_{2019} = 32,175,648 / 38,358,088 = 0.83$$

Энэхүү үзүүлэлт нь нийт хөрөнгөнд эзэмшигчидийн хөрөнгийн эзлэх хувийн жинг харуулна. Энэ коэффициент хэдий чинээ өндөр байна тэр хэмжээгээр өр төлбөр бага гадны санхүүгийн эх үүсвэрээс хараат бус байна. Манай байгууллагын хувьд 2018 онд 0,81 байсан бол 2019 онд 0,83 болж 2,4% өссөн байна.

IV. ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ

“Баянгол Зочид Буудал ХК”-нь хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компанийн нэг бөгөөд хөрөнгийн биржийн В самбарын арилжааны багцад багтдаг.2018.09.04-ний тушаалаар ангилал ахин I ангилалд багтах болсон.

Арилжааны тойм

Ханш				Арилжигдсан		
Дээд	Доод	Нээлт	Хаалт	Ширхэг	Үнийн дүн	Огноо
28,500	28,000	28,160	28,080	35	983,700	2019.1 сар
34,200	28,000	30,166	30,611	227	6,953,000	2019.2 сар
30,000	28,100	29,163	29,298	320	9,387,720	2019.3 сар
29,000	27,000	28,016	28,180	45	1,250,460	2019.4 сар
28,900	27,000	27,833	27,870	146	4,059,100	2019.5 сар
28,200	27,000	27,300	27,160	60	1,628,400	2019.6 сар

/Жич: Сар бүрийн арилжааны дундажаар тооцов/


2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 833 ширхэг хувьцаа 24,462,380 төгрөгөөр арилжаалагдсан байна.

Хувьцаа эзэмшигчидийн бүтэц

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

1	Х.Баттулга	20.00%
2	Х.Баттуул	16.30%
3	Билли Лим Син Пау	16.32%
4	Х.Цэндбаяр	14.79%
5	Халаасны хувьцаа /Цэрэнчимэг/	9.91%

Хувьцаа эзэмшигчид



V. Удирдлага

Õóâüöàà ýçýì ø èãçèä

- Êîì ìàíèé õ°ð° íã°
îðóóèãçèä
- ÒÓÇ-èéí àè ø ÷ ÷ àèéã
ñí íáíõ, ç°è°è°è°
- Õóóèèé í àãáóó ýððýý
á÷ðýí ýäèýð

òóç

- Õóâüöàà ýçýì ø èãçèéã
ð°è°è°éí°
- Êîì ìàíèé ñððàðàãèéã
áíèíãñðóóé íà
- ãëéöýðãýð óäèðäèããüã
óäèðäàà ì æààð òàíããæ
çèãë÷éíý
- ãëéöýðãýð óäèðäèãããã
öýíàèð òààè íà

ãëéöýðãýð óäèðäèããã

- Ñððàðàãèéã
öýðýãæ÷éíý
- ã°ð òóð ì ù í ÷ éè
àæèèèãããã ç°ã
çíðèñðíé çíðèíí
ááéãóóé íà
- ÒÓÇ áíèíí ÕÝ-èéí
° ì í° àæèàà
òàéèããíáíà

ТУЗ-ийн бүтэц, тэдгээрийн компанид үзүүлж буй хувь нэмэр

• ТУЗ-ийн дарга

Нэр	Базарын Аюуш
Боловсрол	МУИС, Оросын ЭЗ-ийн академи
Мэргэжил	Худалдааны нягтлан бодогч, Эдийн засагч
Компанид үзүүлж буй хувь нэмэр	--Аудитын хорооны дарга, --Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны дарга

• ТУЗ-ийн гишүүд

Нэр	Х.Цэндбаяр	Х.Баттуул	Билли Лим	М.Золжаргал	З.Цэрэнчимэг
Боловсрол	Багшийн дээд сургууль, Удирдлагын академи	Багшийн дээд сургууль	Политехн икийн дээд сургууль	БНСУ, Хандонг их сургууль Их Британи EХЕТR их сургууль	МУИС, Удирдлагын академи 2001 онд Магистр
Мэргэжил	Багш, Бизнесийн удирдлага	Биеийн тамирын багш	Инженер	Аялал жуулчлалын зохицуулалтын менежмент	Нябо, эдийн засагч, Бизнес удирдлагын арга зүйч
Компанид үзүүлж буй хувь нэмэр	--Аудитын хорооны гишүүн --Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	--Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны гишүүн			--Аудитын хорооны гишүүн

- ТУЗ-ийн хараат бус гишүүд

Нэр	Д.Батжаргал	Ц.Хэнмэдэх	Д.Цэнддорж
Боловсрол	Ростовын УИС, Маастрихтийн менежментийн сургууль	--Москвагийн УАААД	--1972-1976 он МУИС, --1984-1985 Герман улсад улс төрийн дээд сургууль --1996 ТЗУХИ-ийн удирдах ажилтаны курс
Мэргэжил	Эдийн засагч	Худалдааны бараа судлаач	Инженер, улс төр судлаач
Компанид үзүүлж буй хувь нэмэр	Нэр дэвшүүлэх хорооны дарга	Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны дарга	--Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИЛТ

Нэр	Гишүүнчлэл	Эзэмшиж буй хувьцааны хувь
Билли Лим	ТУЗ-ийн гишүүн	16.32%
Х.Баттуул	ТУЗ-ийн гишүүн	16.30%
Х.Цэндбаяр	ТУЗ-ийн гишүүн	14.79%
З.Цэрэнчимэг	ТУЗ-ийн гишүүн	3.29%
М.Золжаргал	ТУЗ-ийн гишүүн	0%
Д.Батжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Б.Аюуш	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Д.Цэнддорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Ц.Хэнмэдэх	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%